



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 10-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТҮР ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 01 дүгээр сарын 10-ний өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4-15
<i>1. “Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК-ийн нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа, бусад бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтад хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл</i>	4-15

Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы Хянан шалгах түр хороо /Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонгогдох зохион байгуулах, ирээд, олон нийтийг мэдээллээр хангах, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий/-ны 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр /Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл

Хянан шалгах түр хорооны дарга Б.Энхбаяр ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 15 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Бат-Эрдэнэ;

Чөлөөтэй: Э.Бат-Амгалан, С.Ганбаатар, О.Цогтгэрэл.

Нэг. “Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК-ийн нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа, бусад бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтад хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хянан шалгах түр хорооны хянан шалгагч И.Уянга, Ш.Ариунболд, Ч.Анхбаяр, Ж.Батцэнгэл, Ч.Ням-Оюу, Б.Хишигтогтох, Г.Жавхлан, шинжээч Б.Батдэлгэр, Б.Мөнхбат, О.Лхагвадорж, Э.Болормаа, С.Энхзориг, Б.Ариун, Ч.Баярмаа, Б.Сугармаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, референт М.Мандхай, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн зөвлөх Ж.Монголжингоо нар байлцав.

Түр хорооны дарга Б.Энхбаяр “Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК-ийн нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа, бусад бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтад хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Б.Жаргалмаа, Г.Ганболд нарын тавьсан асуултад Түр хорооны дарга Б.Энхбаяр хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, Т.Доржханд нар үг хэлэв.

Б.Энхбаяр: “Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК-ийн нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа, бусад бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтад хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 1
Бүгд: 7
85.7 хувийн саналаар тогтоол дэмжигдлээ.

Байнгын хорооны нээлттэй хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 47 минут үргэлжилж, 11 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 63.6 хувийн ирцтэйгээр 17 цаг 02 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ
ДАРГА

Б.ЭНХБАЯР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр,
Лхагва гараг Төрийн ордон “Их засаг”
танхим 16 цаг 15 минут.

**ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Б.Энхбаяр: Түр хорооны гишүүддээ шинэ оны мэнд хүргэе. Шинэ оны эхний бөгөөд Түр хорооны сүүлийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 63 дугаар тогтоолоор байгуулагдсан Төрийн болон орон нутгийн өмчит өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил үйлчилгээ, худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсгол зохион байгуулах иргэд олон нийтийг мэдээллээр хангах хяналт шалгалтын тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн байна.

Өнөөдрийн хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцэнэ.

1. Хянан шалгах түр хорооны нотлох баримтыг шинжлэн судлах Сонсголын тайлан, санал, дүгнэлтийг хэлэлцэх.

2. Тайлангийн мөрөөр авах дагасан Улсын Их Хурлын тогтоолын төсөл гэсэн ийм 2 асуудлыг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа орёе.

Эхний асуудал нь, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэгт зааснаар хаалттай хуралдаж шийдвэрлэх асуудал учраас хуралдааныг хаалттай горимд шилжүүлэе.

Хуралдаан нээлттэй горимд шилжсэн.

Дараагийн асуудал.

Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэгт зааснаар хаалттай хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааны нээлттэй горимд шилжүүлэе.

Хянан шалгах түр хорооны хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Тогтоолын төслийг гишүүдэд тараасан байгаа. Миний бие уншиж сонсоё. Монгол Улсын Их Хурлын тогтоол.

Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооноос ЭТТ ХК, Тавантолгой ХК-ийн нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа, бусад бараа, ажил үйлчилгээ, худалдан авалтад хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай.

Төрийн болон орон нутгийн өмчит өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа, бусад бараа, ажил үйлчилгээ худалдан авалтад хяналт шалгалт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах үүрэг бүхий Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос зохион байгуулсан Нээлттэй сонсгол нь шударга ёсыг тогтоож, иргэдийн мэдэх эрхийг хангах, ард түмэн сонгож байгуулсан төрийн бүх шатын байгууллагын үйл

ажиллагаанд хяналт тавих, байгалийн баялгийг нийтийн эрх ашигт нийцүүлэн ард түмний амьдрал ахуйг сайжруулж улс орны эдийн засгийг хөгжүүлэхэд зориулан зүй зохистой ашиглах, Монгол Улсын үндсэн хуулийн үзэл баримтлал заалтыг хэрэгжүүлэхэд чухал нөлөө үзүүлэх арга хэмжээ болсныг цохон тэмдэглэж, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн нэг дэх хэсэг мөн зүйлийн 2 дахь хэсгийн 1. 2 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь.

Нэг. Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооноос ЭТТ ХК, Тавантолгой ХК-ийн нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа, бусад бараа, ажил үйлчилгээ, худалдан авалтад хийсэн хяналт шалгалттай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

1.Монгол Улсын Үндсэн хууль, Газрын тухай хуулийг зөрчиж гадаадын хөрөнгө оруулалттай ААН-д газар эзэмшүүлсэн асуудлыг шуурхай шалгаж, холбогдох шийдвэрийг хүчингүй болгох арга хэмжээ авах.

Хууль зөрчин газар эзэмшүүлэх шийдвэр гаргасан албан тушаалтнуудад хариуцлага тооцох.

2.Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд улс төрийн нөлөө бүхий этгээд тэдгээрийн хамаарал бүхий этгээд ажиллах, аж ахуй, бизнесийн үйл ажиллагаанд улс төрийн нам улс төрчид оролцохыг таслан зогсоож хязгаарлах арга хэмжээ авах.

3.ЭТТ ХК, Тавантолгой ХК болон төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой бусад хуулийн этгээдийн зүгээс цаашид төсвийн шинжтэй компанийн үйл ажиллагаанд хамааралгүй хөрөнгө оруулалт, төслийг санхүүжүүлэхгүй байх, хориглох арга хэмжээ авах.

4.Төрийн болон орон нутгийн өмч төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн аж ахуй бизнесийн үйл ажиллагаанд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс аливаа хэлбэрээр оролцохыг хязгаарлах, тэдгээрийн компанийг хязгаарлах, тэдгээрийн компанийн засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоог сайжруулах үйл ажиллагаагаа иргэд олон нийтэд ил тод нээлттэй явуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх хуулийн төсөл боловсруулж 2024 оны 1 дүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

5.ЭТТ ХК, Тавантолгой ХК болон төрийн болон орон нутгийн өмчит төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой бусад хуулийн этгээдийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг иргэд олон нийтэд ил тод нээлттэй зохион байгуулах чиглэлээр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулж 2024 оны 1 дүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

6.Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн баялаг гагцхүү ард түмний мэдэлд төрийн хамгаалалтад байна гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан, төрийн нийтийн өмч мөн гэж тус тус хуульчилсан тул Тавантолгой ХК-ийн төрийн эзэмшлийн

51 хувийн хувьцааг орон нутгийн өмчлөлд шилжүүлсэн. Аймаг нийслэлийн өмчлөлд эд хөрөнгө шилжүүлэх тухай Улсын Их Хурлын 1999 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 29 дүгээр тогтоолын холбогдох заалтыг хүчингүй болгож, төрийн өмчлөлд эргүүлэн авах тогтоолын төслийг боловсруулан 2024 оны 1 дүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

7.Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт орших Тавантолгой чулуун нүүрсний бүлэг ордын эм 5011956 тусгай зөвшөөрөлтэй Бортээгийн уурхайн гэрээт олборлогчийг сонгон шалгаруулахдаа төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчсөн тул ЭТТ ХК-ийн импасс түшлэлтэй 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр байгуулсан Тавантолгойн ордын Бортээгийн уурхайн хөрс хуулалт, өрөмдлөг, тэсэлгээ, нүүрс олборлолт, нүүрс баяжуулалтын ажил, гүйцэтгэх гэрээг холбогдох хууль журмын дагуу хүчингүй болгох арга хэмжээ авах.

8.Татварын хяналт шалгалтыг хуульд заасан журмын дагуу зохион байгуулуулаагүйн улмаас нүүрс олборлогч зарим хуулийн этгээд татвараас зайлсхийх нөхцөлийг бүрдүүлж, татвар авах, нөхөн болон алданги, торгууль ноогдуулах боломжийг алдагдуулсан албан тушаалтнуудад холбогдох хууль журмын дагуу хариуцлага тооцож, цаашид дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр татварын хууль тогтоомжийг боловсронгуй болгох хуулийн төсөл боловсруулж 2024 оны 1 дүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

9.Монгол Улсын хилээр гаалийн бүрдүүлэлтгүй нүүрс тээвэрлэх, экспортлох нөхцөлийг бүрдүүлж, татвараас зайлсхийх нөхцөлийг бүрдүүлсэн албан тушаалтнуудад холбогдох хууль журмын дагуу хариуцлага тооцож дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион

байгуулах. Гааль болон хилийн хяналтын хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр хуулийн төсөл боловсруулж 2024 оны 1 дүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

10. ЭТТ ХК, Тавантолгой ХК-ийн нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа, бусад бараа, ажил үйлчилгээ, худалдан авалтад хийсэн Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авч хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй түр хорооны үйл ажиллагаанд саад учруулсан албан тушаалтнуудын хариуцлагын асуудлыг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооноос ЭТТ ХК, Тавантолгой ХК-ийн нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа, бусад бараа, ажил үйлчилгээ, худалдан авалтад хийсэн хяналт шалгалтаар илэрсэн гэмт хэргийн шинжтэй үйлдэл эс үйлдлийг холбогдох хуулийн дагуу шалгаж шийдвэрлүүлэхийг Монгол Улсын ерөнхий прокурор Б.Жаргалсайхан, Авлигатай тэмцэх газар Д.Даидаваа, Цагдаагийн ерөнхий газар Д.Сүхболдод тус тус зөвлөсүгэй.

Гурав. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо Н.Энхболд, Хууль зүйн байнгын хороо Д.Цогтбаатар тус тус даалгасугай.

Дөрөв. Энэ тогтоолыг 2024 оны .. дугаар өдрөөс эхэлж дагаж мөрдсүгэй гэсэн тогтоолын төсөл байна.

Тогтоолын төсөлтэй холбоотойгоор асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү? Ганболд гишүүнээр тасаллаа. Оюунчимэг гишүүн асуултаа асууя.

М.Оюунчимэг: Ерөнхийдөө гол санаанууд бол орчихсон байна. Энэ дээр яг түрүүн бид нар шинжээчдийн дүгнэлт дээр хэлж байсан шиг нөгөө хамгийн гол сая яригдаад байсан асуудлууд одоо бас маргаан үүсгээд байгаа зүйл нь юу юм гэхээр нөгөө статистикийн тоо баримтууд хоорондоо зөрчилтэй харилцан адилгүй. Нэг нь сая жишээ нь 6.1, 2 сая гэхэд нэг ч гараагүй гэдэг юм уу. Тэгэхээр нэгд, статистик тоо баримтуудын энэ зөрүүтэй байгаа төрийн нүд, чих болсон байгууллагуудын.

Тэгэхээр энэ дээр тодорхой нэг үүрэг чиглэл өгч, үүнийг нэгдсэн 1 платформтой болгох энэ ажлыг хийхэд нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар ч юм уу, үүрэгжүүлж өгөөд хугацаатай үүрэг өгөөд эргэж танилцуулах тийм зүйл өгсөн нь зөв болов уу гэж бодож байна. Бас нөгөө архивын материал алдагдсан гэдэг асуудал бол сая нүүрсний түр хорооны хоёр ч удаагийн энэ хурлаар хамгийн ноцтой асуудлууд бол архивын материал байхгүй, архивын материал устсан. ЭТГ-г дээр ч гэсэн, жижиг Тавантолгой дээр ч гээд том, том ААН-үүд дээр ч гэсэн архивын материал олдоогүй энэ байхгүй байсан гэх мэт зүйлүүд байсан. Тэгэхээр үүнийг бол маш хариуцлагатайгаар үүрэгжүүлж өгөөд эргээд энэ бол хариуцлага тооцох асуудлыг яг энэ Улсын Их Хурлын тогтоол дээр тусгаж өгөх нь зүйтэй гэсэн байр суурьтай байна.

Нөгөө талаасаа энэ Түр хорооны хуралд дуудсан гэрчүүд хүндэтгэх шалтгаангүйгээр ирээгүй тохиолдолд ямар арга хэмжээ авдаг ямар хуулийн заалт байгаа юм. Эсхүл энэ хуулийн заалт эрх, үүргийг нь тодорхой ойлгох энэ заалтыг Улсын Их Хурлын тогтоол дээрээ бас зааж өгсөн нь зөв болов уу гэж бодож байна. Ирж ч болох юм шиг, ирэхгүй байж ч болох юм шиг тийм ойлголт бас сая нийгэмд өглөө л дөө. Тэгэхээр энэ заалтаараа бас торгох ч юм уу заалттай юм байна л даа. Тэр нь гол биш ер нь ирэх л ёстой, хүндэтгэх шалтгаантай бол түүнийгээ албан

бичгээр ингэдэг байх ёстой гэсэн тэр эрх, үүргийг тодорхой болгож өгөх. Сая ингээгүй тохиолдолд яах ёстой вэ гэдгийг бас энэ Их Хурлын тогтоол дээрээ зааж өгвөл ямар болов уу гэж бодож байна.

Тэгээд хамгийн сүүлийн асуулт нь одоо бид энд хяналт тавьж ажиллахыг Төрийн байгуулалтын байнгын хорооны болон Хууль зүйн байнгын хорооны дарга нарт даалгавар болгосон байна. Одоо яг хууль хяналтын байгууллага жишээлбэл ажлаа хийх үлдэж байна. Тэгэхээр яг үүний дагуу ажилласан тэр тайлангаа Улсын Их Хуралд эргээд АТГ ч гэдэг юм уу намрын чуулганаар тайлагнах ч юм уу, тэгж тогтоолд тусгах бололцоо байгаа юу. Ийм асуултууд байна. Баярлалаа.

Б.Энхбаяр: Сонсголд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй иргэн хүн албан тушаалтнуудад Хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу зөрчлийн арга хэмжээ шийдэх асуудлыг Тогтоолд заавал оруулахгүй, нэгэнт хуультай байгаа юм чинь Тамгын газарт угаасаа нэрс нь байгаа. Тэгэнгүүт түүнийг нь албан бичгээр шууд цагдаа руу хүргүүлээд бүгдийг нь шийтгэчихье. Түүнийг заавал тогтоолд яах юм байхгүй гээд шийдчихье.

Хоёрт нь, эргэж яаснаа мэдээлнэ гэхээр бид чинь хууль тогтоох байгууллага нөгөөдөх маань шүүх эрх мэдлийн асуудал болчихоод байгаа юм. Энэ чинь гэмт хэргийн асуудал яриад байгаа юм. Гэмт хэргийн асуудлыг Улсын Их Хуралд тайлагнадаг тийм асуудал Үндсэн хуулиар байхгүй. Мөрдөн шалгах үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцож болохгүй. Тийм ч учраас энэ 2 дахь заалтад зөвлөсүгэй гэдэг агуулгаар гарч байгаа юм. Даалгасугай гэж гарч болохгүй. Даалгасугай гэвэл бас Үндсэн хуулиа зөрччих гээд байгаа юм. Мөрдөн шалгах ажиллагаа гэмт хэргийн асуудал болчихож байгаа учраас.

Тийм учраас таны хэлж байгаа үнэн. Үнэхээр Улсын Их Хурал буюу хууль тогтоох институтуц бол ард түмний

төлөөллийн байгууллагынхаа чиг үүргийг хэрэгжүүлж, ард түмний мэдэх эрхийг бол хангаж ажиллалаа. Одоо энэ мэдэх эрхийн хүрээнд ил болсон гэмт хэргийн шинжтэй энэ асуудлуудыг шуурхай хянан шийдвэрлэж хариуцлага тооцох асуудал бол цэвэр шүүх эрх мэдэл буюу одоо мөрдөн шалгах ажиллагааны байгууллагуудын үр дүнгээс хамаарах байгаа. Мөрдөн шалгах байгууллагуудын үйл ажиллагаа руу одоо ард түмэн тэр чигээрээ ард түмний төлөөллийн байгууллага бид ч мөн тэр чигээрээ нэхэл хатуутай харах болно. Нэхэл хатуутай харах болно. Гэхдээ энэ хугацаатай гэдгийг бол бас ойлгох ёстой.

Энд мэдээж Ерөнхий прокурор, АТГ дийлэнх нь авлига, албан тушаалын хэрэг учраас АТГ гэж орж байгаа. Цагдаа бас яагаад ороод явчлав гэхээр яах вэ, зарим бас хөрөнгө мөнгө шамшигдуулсан, хөрөнгө завиш гэмт хэрэг цагдаагийн харьяалалд байдаг. Мөнгө угаах гэмт хэрэг цагдаагийн харьяалалд байдаг. Тэгэхээр энэ гэмт хэргийг шалга гэдгийг даалгаж болохгүй байгаа юм. Энэ бол хуулиараа зөвхөн прокурор даалгадаг ажил. Прокурорын хуулиар зөвхөн прокурор даалгавар өгдөг юм. Тэгэхээр Улсын Их Хурал хууль тогтоох байгууллага даалгавар өгч болохгүй байгаа юм. Гэмт хэрэг дээр чи үүнийг үгүй ээ, харин чиглэл өгчхөж болохгүй байгаа юм.

Тэгэхээр чиглэл ч өгч болдоггүй, даалгавар ч өгч болдоггүй. Бид нар чинь нөгөө тэгээд л халтирвал Үндсэн хуулийнхаа нөгөө хилээ авчих гээд байна.

Тийм учраас зөвлөсүгэй гээд. Тэгэхдээ үүгээр гарсан бүх материалуудыг би 3 хувь бүх нотлох баримтуудыг бэлдчихсэн байгаа. 3 хувь. Тэгээд маргааш 1 хувийг нь АТГ-т, 1 хувийг нь цагдаагийн байгууллага руу, 1 хувийг нь Монгол Улсын ерөнхий прокурор руу хүргүүлэх гэж байгаа юм. Албан ёсоор энэ нотлох сонсголоор гаргасан бүх нотлох баримтуудыг

хүргүүлэх гэж байгаа юм гэдгийг гишүүддээ хэлье.

Архивын юуг Оюунчимэг гишүүн, тэр биг датаг, бас ер нь тогтоолын төсөлдөө тусгачихъя. Тэгээд архивын асуудал нөгөө төрийн байгууллагуудын энэ тоон статистикгүй зөрөөд байна гэдэг асуудал сонсголоор яригдсан шүү дээ. 4 байгууллагын тоо дөрвүүлээ зөрсөн гэж. Тэгэхээр энэ тоо зөрдөггүй байх гэхэд хаашаа юм, үнэн зөв бид нар өгөгдөлтэй болох асуудлыг ер нь энэ тогтоолын төсөлд бас оруулж тусгая Ююунчимэг гишүүний хэлсэн. Жаргалмаа гишүүн үгээ хэлье.

Б.Жаргалмаа: Би нэг зүйл тодруулах гэсэн юм. Би өөрөө нөгөө ЭТТ-н хувьцаа эзэмшигч, 1072 хувьцаа чинь надад байгаа шүү дээ. Тэгэхлээр би энэ ЭТТ компанитай нэгдмэл сонирхолтой этгээд л дээ нөгөө хувьцаа эзэмшиж байгаа учраас. Тэгээд энэ 3 дээр байгаа ЭТТ ХК болон төрийн болон орон нутгийн өмчид төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой бусад хуулийн этгээдийн зүгээс цаашид төсвийн шинжтэй компанийн үйл ажиллагаанд хамааралгүй хөрөнгө оруулалт, төслийг санхүүжүүлэхгүй байх, хориглох арга хэмжээ авах. Энэ хэрэгжих боломжтой юу, үгүй юу гэж би гайхаад байна. Өөрөөр хэлбэл тодорхой хэмжээнд төсвийн томоохон хөрөнгө оруулагчийн хувиар ЭТТ компани Засгийн газраас хэрэгжүүлж байгаа олон төсөл хөтөлбөрт бас оролцдог. Тэгэхлээр энэ ер нь боломжтой юм болов уу л гэж би асуух гэсэн юм. Яг өнөөдөр ер нь хэчнээн төсөл хөтөлбөрийн санхүүжилтийг хийж байдаг юм бол гэж.

Нөгөөтээгүүр миний түрүүний яриад байсан орон нутгийн өмчийн оролцоотой бусад ААН, этгээдийн бараа, үйлчилгээ худалдан авах, өөрөөр хэлбэл энэ тендерийн үйл ажиллагаанд иргэд олон нийтэд нээлттэй байх зохион байгуулах чиглэлээр үүрэг өгч байгаа нь энэ 5 дээр орчихлоо гэж ойлгож байна.

Зөв үү. Миний хүсэлт, миний түрүүний тавиад байсан шаардлага маань 5 дээр орчихлоо гэж ойлгож байна. Зөв үү, үгүй юу. Ийм 2 асуулт байна.

Өнөөдөр ер нь ЭТТ хэчнээн төсөл хөтөлбөрийг санхүүжүүлдэг юм бол оо? Бид нар бас нэг боломжит шаардлага тавихгүй бол.

Б.Энхбаяр: Хэчнээн ийм төсвийн шинжтэй арга хэмжээг санхүүжүүлж байгаа вэ гэдэг асуудал бол энэ тайландаа байгаа, дэлгэрэнгүй байдлаар байгаа. Тогтоолын төслийн 3-т байгаа. Ер нь цаашид төсвийн шинжтэй компанийн үйл ажиллагаанд хамааралгүй хөрөнгө оруулалт, төслийг санхүүжүүлэхгүй байх, хориглох чиглэлээрх арга хэмжээ болон 4-д заасан энэ ер нь төрийн болон орон нутгийн өмчийн компаниудын аж ахуйн үйл ажиллагаанд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс зөвлөмж хэлбэрээр аливаа хэлбэрээр оролцдог шийдвэр гаргадаг. Үүнийг хязгаарлах гэсэн ийм асуудал бол томьёоллын хувьд 2024 оны 1 дүгээр улиралд хуулийн төсөл боловсруулж өргөн барих гээд энэ ер нь шаардлагагүй.

Яагаад гэхээр Төрийн болон орон нутгийн өмчийн тухай болон төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хууль Улсын Их Хуралд өргөн баригдчихсан байгаа. Энэ хууль дээр нь яг энэ дурдсан 2 асуудлыг саналын томьёолол нь бол ажлын хэсгийн түвшинд бэлтгэгдсэн байгаа. Би өөрөө ажлын хэсгийн ахлагч. Ер нь бол өөртөө үүрэг өгүүлчихье гэж байгаа юм. Тэгэхгүй бол бас үүнийг энэ чигээр нь байлгах сонирхолтой бас хүмүүс байгаад байгаа шүү дээ. Тэгэхээр ер нь Их хурлын тогтоолдоо оруулаад, шийдвэр гаргуулаад тэгээд түүнийхээ дагуу тэр саналын томьёоллоо Их Хурлынхаа үүргийн дагуу оруулаад явбал гэдэг утгаар. Ер нь үүний дагуу мөрөөр хийгдэх хамгийн том нэг реформ хийгдэх ёстой нь төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль. Цоо шинээр нь иж

бүрнээр нь бүгдийг нь шинэчлэх асуудал байгаа юм. Үүнийг бол би ч их ярьсан өөрөө ч ажлын хэсгийг нь ахалсан. Бэлтгэхээд байгаа юм.

Тэгээд одоо чуулган хаах гээд байгаа, сонсгол гэсээр байгаад хууль руугаа орж чадсангүй. Энэ хаврын чуулган дээр эхлэнгүүт саналын томьёололыг нь шууд батлуулахаар бэлэн болгочихсон байна гэдгийгээ харин амлаж байна.

Тогтоол дээр 1 дүгээр улиралд багтаан хуулийн төсөл боловсруулж өргөн барих гэхээр энэ боловсруулаад өргөн барьчихсан юм. Ер нь бол хуулийн төсөл нь.

Саналын томьёоллыг жаахан найруулъя. Таны санал, тендер худалдан авалтын хуулийг өөрчлөлт бас оруулах шаардлага байна. Яагаад гэхээр, энэ чинь их том дүнтэй. Бид нар бол ерөнхийдөө сая сонсгол дээр харлаа шүү дээ. Хааидаа шалгаад үзэхээр ЭТТ-н тэр хөрс хуулалтын 600, 700, 800 тэрбумын тендерүүд чинь яг үзэхээр хуулийн асуудал байхгүй. Яагаад, угаасаа түүнийг хангасан Монголд нэг л компани байгаа юм. Түүнийг ингээд харахад тендер байхгүй юу. Тэгээд борлуулалтын орлого нь 1 их наядын борлуулалтын орлоготой байна гээд тавьчихаж байна шүү дээ. Тэгээд түүнийг чинь хангаж байгаа нэг л компани байгаа юм.

Тэгэхээр энэ өрсөлдөөнийг хязгаарладаг, хааидаа яг энэ том компанийн хувьд тендерийн хууль нь онцлог байх ёстой юм байна билээ. Тэр чиглэлээр нь холбогдох хуулийн төслийг нь өргөн барь гэдэг заалт нь бол энэ 5 дахь заалтыг нь хэлж байгаа энэ заалт юм аа. Ганболд гишүүн асуултаа асууя.

Г.Ганболд: 3 дахь заалт бол зөвөө ингэж орох ёстой. Ер нь төрийн өмчит компаниуд ноогдол ашгаа дивидендээрээ төр аваад, тэгээд төсвийн бүрэлдэхүүн хэсэг болгоод батлаад явах ёстой. Тэгэхгүй явснаар

одоо нэг төрийн өмчит компанийн худалдан авалт нь улсын төсвөөсөө давчихсан, улсын төсвийнхөө хөрөнгө оруулалтаас давчхаад явж байна шүү дээ. Бараг нэг гэрээг нь давчхаад явж байна. Тэгээд үүнийг хориглох нь зөв гэж бодож байна. Би 6 дугаар заалт дээр л нэг жаахан эмзэглэж байна. Бид нар бүсчилсэн хөгжил гээд явж байна. Төвлөрлийг сааруулна гээд явж байна. Орон нутгийг хөгжүүлнэ гээд явж байна. Тэгээд энэ 6 дугаар заалтаар бид нар энэ Тавантолгой компанийн 1999 оны 29 дүгээр тогтоолыг хүчингүй болгох энэ заалт бол өөрөө буруу. Өмнөх үеийнхний алдааны нэг золиос нь ирээдүй хойч үеийнхэн байж ерөөсөө болохгүй.

Тухайн үед Өмнөговийн иргэдийн хурлынхан буруу шийдвэр гаргаж байсан. Одоо энэ нүүрсний сонсголоор тэр ил боллоо. Одоо цаашидаа энэ орон нутаг алдаа гаргахгүй үүнийг аваад явчих боломж байгаа гэж би бас бодож байна. Зөвхөн үүнээс ингээд ярих юм бол орон нутгийн иймэрхүү уурхайнууд зөндөө байгаа, орон нутгийн шинжтэй. Төр авснаараа ч сайн болоод явж байна гэж байхгүй. Төрийн Тавантолгой ч гэсэн ялгаагүй л байна. Тэгэхээр би энэ 6 дугаар зүйлийн энэ Тавантолгой компанийг төрд авч хүчингүй болгож төрд авахыг нь 1 дүгээр улиралд багтаан өргөн барь гэдгийг би дэмжихгүй байна.

Харин түрүүний тайлан дээр байсан тэр тайлангийн цаашид авах арга хэмжээний Монгол Улсын Үндсэн хууль бусад хууль тогтоомжид ч нийцүүлэн нийцэж буй эсэхийг шалган шаардлагатай арга хэмжээ авах гэдэг ийм заалтаар оруулж явахгүй бол энэ заалтыг би дэмжихээргүй байна. Би дахиад хэлье. Өмнөх алдаа гаргасан тэр иргэдийн хурлынхны тэр алдааны золиос нь бол ирээдүй хойч үе, одоогийн залуучууд нутгийн иргэд байж ерөөсөө болохгүй.

Б.Энхбаяр: Ганболд гишүүний асуултад харцулъя. 6 дугаар заалт буюу орон нутгийн өмчийн Тавантолгой ХК-

ний 51 хувийн хувьцааг орон нутгийн өмчлөлөөс төрийн өмчлөл рүү шилжүүлэх асуудал байгаа юм. 1999 онд төрийн өмчөөс орон нутгийн өмч рүү шилжүүлээд өгчихсөн. Түүнийг нь хүчингүй болгочихъя гэж байгаа юм. Тэгэхээр төрийн өмч рүү ирнэ гэсэн үг. Үүнийг оруулах 2 үндсэн том шалтгаан үндэслэл байна гэж нэгдүгээрт үзэж байгаа.

Нэгд, Монгол Улсын Үндсэн хууль. Сая хэлсэнчлэн газар, газрын хэвлий энэ байгалийн баялаг бол нийт ард түмний мэдэлд төрийн хамгаалалтад байна гэдэг Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн нэг дэх заалт байгаа. Нэг аймгийн биш нийт ард түмний, 2 дахь Үндсэн хуулийнх нь одоо гол асуудал бол Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар төрийн нийтийн өмч байна гэж байгаа. Орон нутгийн өмч гэж байхгүй. Шүүд Үндсэн хуульд угаасаа төрийн нийтийн өмч байна гээд хэлчихсэн байгаа. Тийм учраас Үндсэн хуульд нийцүүлэх гэж байгаа гэсэн үг.

Хоёр дахь үндэслэл нь хяналт шалгалтаар тогтоогдсон асуудал бол энэ орон нутгийн жижиг Тавантолгой хэн эзэн суух вэ гэдэг бүлэглэлийн асуудал Өмнөговь аймагт бий болсон. Сонсголоор бол сонсголд оролцож байгаа Бат-Эрдэнэ гишүүн хүмүүс бол хэлж байсан. Өмнөговьчуудынхаа ард түмний төлөө энэ Тавантолгойн ард хөгжөөд байсан гэж байна. Тийм юм байхгүй. Бат-Эрдэнэ ба түүнийг тойрсон бүлэглэлүүд Тавантолгой гэдэг ордыг Өмнөговьчуудын харин нэрийг барьж хулгай хийсэн, өөрсдөө баяжсан ийм нөхцөл байдал л тогтоогдсон. Өмнөговьчуудын хэдэн хишиг хувь тараасан гэдэг нэр нь энэ бол хулгай нүглээ, нүглийн нүдийг гурилаар хуурах гэсэн ийм зүгээр л нэг бодлын авлига.

Өмнөговь аймгийн ард иргэдийг авлигадаж байгаа асуудал энэ бол. Ийм л нөхцөл байдал тогтоогдсон. Үүний том зураг нь юу вэ гэхээр цаашидаа Монгол Улс хилийн дагуу байршиж байгаа ийм

орд газруудыг түшиглэсэн хэлбэрээр орон нутагт өмчлүүлэх нь өөрөө аймгуудыг хувьчилж авсан, эзэн суусан хуучин цагаар бол феодалууд, одоо цагийнхаар бол олигархууд төрж гарах, тэд нар нь газар нутгаа худалдах, салан тусгаарлах, ийм үндэсний аюулгүй байдлын эрх ашигт нөлөөлөх үр дагавартай гэж үзэж байгаа. Газрын тосыг Дорнод аймгийнхны өмч өө гээд хэрвээ ингээд өгчих юм бол сүүлдээ тэгээд юу болохыг би мэдэхгүй байна. Зөвхөн тэр аймгийнхны өмч гээд. Тэнд бас нэг хэдэн помещик шиг л төрнө. Асгат дээр Баян-Өлгий аймгийнхны өмч гээд л хувьчлаад өгчих юм бол тэр аймгийнхны өмч гээд л одоо тэгээд яах юм бүү мэд.

Ер нь энэ дэлхийн улс орнуудаа байгаа зүйлүүдийг харахад, улс орноос салан тусгаарлах оролдлого хийж байгаа, иргэний дайн дэгдээж байгаа оролдлогууд дэгдээж байгаа муж тийм штат зүйлүүд нь дандаа байгалийн баялгийн ордтой эсвэл тийм ихээхэн баялагтай мужууд нь тийм оролдлогуудыг гаргаад байгаа.

Жишээлбэл Испанийн тэр муж сүүлд салан тусгаарлах оролдлого хийгээд тэр мужийн бүх иргэдийн хурлын төлөөлөгч нарыг төрийн эсрэг гэмт хэрэг хийснээр, Үндсэн хууль зөрчсөнөөр Испанийн шүүх шийдсэн байгаа юм. Гадагшаа зугтсаныг нь барьж авчирч байгаад. Яагаад тэр хүмүүс тэгсэн гэхээр тэнд хамгийн их байгалийн баялагтай, хамгийн их татвар төлдөг. Түүгээрээ бүүр ингээд би энэ бусад улс оронд байгалийн баялаггүй энэ хүмүүсийг яагаад бид тэжээх ёстой юм гэдэг рүүгээ орчихдог. Яагаад энэ бусад аймгууд өөрсдөө өөрсдийгөө аваад явж чаддаггүй юм. Бид нар яагаад энэ хүмүүсийг тэжээх ёстой юм гэдэг ийм сэдэл төрдөг.

Тийм учраас ийм сэдэл рүү орох зүйлийг би Монгол улсын Ерөнхий сайдын зөвлөхөөр Өмнөговь аймагт ажиллаж байхад Монгол Улсын Ерөнхий сайдыг

хэвлэлийн хурал хийх танхим олгохгүй байсан. Өмнөговь аймгийн ИТХ-ын дарга нь Монгол Улсын Ерөнхий сайд оччихсон байгаа шүү дээ. Ингэтлээ даам гарчихсан байхгүй юу. Тийм учраас энэ асуудлыг би ерөөсөө ийм санал санаачилгыг бол хэрхэвч өөгшүүлж болохгүй гэж бодож байгаа юм. Тэгэхдээ Ганболд гишүүний хэлсэн асуудлаар санал хураалгана тусад нь. Өөрөөр хэлбэл, Өмнөговь аймгийн Тавантолгой компанийн 51 хувьцааг төрийн өмчлөлд буцаан шилжүүлэх асуудлыг та чинь хасъя гэсэн. Эндээс нь хасъя.

Энд тэр ажнай Бат-Эрдэнийн хувьцааг нь авах тухай ерөөсөө яриагүй. Хувь хувийнх нь юм уу хөрөнгийн бирж дээр гарчихсан хувьцааг нь яриагүй байхгүй юу. Энэ Өмнөговь аймгийн Иргэдийн хурлын өмчлөлд шилжчихсэн 51 хувийн хувьцааг орон нутгаас нь төрд нь авах тухай ярьж байгаа болохоос тэр Ажнайгийн хувийн өмч рүү орох тухай ерөөсөө Их Хурал хувийн өмч рүү халдсан тийм юм яриагүй. Үүгээр санал хураалгая.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Доржханд гишүүнээр тасаллаа. Сүхбаатар гишүүн үгээ хэлье.

Ж.Сүхбаатар: Ганболд гишүүн, Энхбаяр гишүүн хоёрын яриад байгаа асуудал. Тэр бол яагаад ингээд төрийн бодлого тодорхой болж өгөхгүй байгаа юм гэхээр Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль бол үнэхээр хоцрогдчихсон юм. Тэр Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль чинь гараад 27, 28 жил болчихсон, суурь концепц нь өөрчлөгдөөгүй байгаа. Тэгээд орон нутаг яг ямар өмчтэй байх юм бэ гэдэг асуудал дээр Европын болон бусад улс орнууд бол орон нутгийнхаа тухайн газрынхаа ой модыг ч эзэмшиж байдаг, газрыг ч өмчилж байдаг гэж. Тэгээд захиран зарцуулж байдаг байхгүй юу.

Ингээд янз бүрийн байгалийн баялгийг. Манай Үндсэн хуулийн

концепцоор бол тийм биш болгочихсон. Болгочихсон ч гэж дээ угаасаа тэгж явж ирсэн. Байгалийн баялаг бол одоо нийт ард түмний мэдэлд төрийн өмчийн одоо ийм чиглэлтэйгээр байдаг, ийм болгочихсон. Ер нь цаашидаа төв орон нутаг, бүсчилсэн хөгжил гээд явахад орон нутаг гэдгийг одоогийн аймаг, сумаар нь үзэхэд хамаагүй өмч өгөөд явах нь бол концепцын хувьд буруу байгаа юм. Яваандаа бүс нутаг хөгжиж байгаа үед, тодорхой хотууд, тосгод гэж ярина л даа. Хот, тосгонууд бол өөрийн өмч хөрөнгөтэй байх тухай асуудлууд яригдах хүрээнд одоо бусад оронд бол хот, тосгон нь өөрөө өмчтэй байгаа шүү дээ. Тэр мод тариад өөрсдөө ой мод хүртэл бий болгоод, тэрийгээ одоо ашиглаж зарж үрж байдаг философи нь арай өөр л дөө. Тэгэхээр манайд бол арай өөр. Энэ өмчийн концепцын асуудал бол би ойлгохдоо мэргэжлийн хүн биш. Гэхдээ иргэний эрх зүйн талаасаа Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль эд нараар төрийн бодлогынхоо асуудлыг ойрын хэдэн асуудлыг ойрын хэдэн жилийн асуудал одоо зөв тодорхойлох ёстой.

Гэхдээ сүүлд орсон Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн хүрээнд бол байгалийн баялгийн асуудлыг бол төрийн ард түмний мэдэлд ингээд чиглэл рүү оруулчихсан. Тэгэхээр цаашидаа байгалийн баялаг ихтэй аймаг сумд одоо ингээд аймаг сумд бол байгалийн баялгаа одоо өөрсдөө орон нутгийн өмчит компани байгуулах замаар ингээд яг өмчлөөгүй ч гэсэн өмчилсөн хэлбэртэй ингээд явах нь бол асуудалтай байгаа нь бол үнэн.

Тэгэхээр яг энэ асуудлыг би Энхбаяр гишүүний оруулж ирж байгаа тэр тогтоолын төслийн хүрээнд дэмжиж байна. Гэхдээ мэдээж Их Хурал дээр энэ нэлээн яриа болно. Түрүүн Ганболд гишүүний хэлдгээр сонгууль дөхчихсөн үе байдаг. Бас Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиа бид бас гаргаагүй байдаг. Тэгэхээр сигнал нь яаж өгөгдөх юм бэ гэдэг асуудал дээр зөв юм шиг боловч сигналаа бас бодох ёстой.

Түүн дээр Түр хорооны дарга тайлбараа зөв хэлэх ёстой. Үндсэн хуулийн асуудал байна. Гэхдээ энэ асуудал дээр төр, орон нутагт өгсөн өмчүүдийгээ эргэн харах асуудал дээр одоо Үндсэн хуулийн заалтыг хэрэгжүүлэх хүрээнд явж байгаа бол түүнийгээ бас зөв ойлгуулах асуудал гарна л даа.

Ер нь сая сонсголоос харахад Орон нутгийн өмчид шилжүүлээд орон нутгийн өмчид шилжүүлснийхээ хэмжээгээр нөгөө цаад талын хувийн өмчид байгаа нөхдүүдтэй найрсдаг. Тэртээ тэргүй манай орон нутгийн битгий хэл төрийн өмчийн менежмент муу байгаа, Ганболд гишүүн ээ. Манай улс төрийнхөө өмчийн менежментийг хийж чадахгүй байхад орон нутаг өөрийнхөө өмчийн менежментийг сайн хийж чадна хийж чадна гэдэг юм бол байхгүй. Олон улсын экспертүүдийн хувьд ч гэсэн төрийн эрх мэдлийг одоо төвлөрлийг сааруулах хүрээнд эрх мэдлийг шилжүүлэхдээ нэг асуудлыг ярьдаг. Төвлөрлийг сааруулж байна гээд төвд байгаа эрх мэдлийг орон нутагт өгөхөөр орон нутгийн засаглал хяналт муу байгаа үед орон нутагт байгаа жижиг бүлэглэлүүдэд дураараа дургих ийм боломжийг өгдөг гэдэг ийм зөвлөмжийг өгдөг юм.

Тэгэхээр орон нутгийн засаглал хяналт сайн байж байж орон нутагт тодорхой эрх мэдлүүд өгөгдөж байхгүй бол үр дүнгүй байдаг гэсэн ийм ОЕСТ-ийн экспертүүдийн олон жилийн өмнө өгч байсан, байнга ч өгдөг зөвлөмжүүд бол энэ байгаа. Тэгэхээр Өмнөговь аймгийн орон нутгийн өмчийн менежментийг засаж чадна гэвэл Ганболд гишүүний хэлдгээр үнэн, засаж чадна гэвэл. Гэтэл тэр засдаг тэр механизм нь бидэндээ одоо тэр орон нутгийн өмчийн юман дээр байна уу үгүй юу? Бид чинь одоо ЭТТ гээд төрийн өмчийнхөө менежментийг янзалж чадахгүй байгаа хүмүүс шүү дээ. Тэгэхээр энэ хууль ингээд гараагүй байна. Гэхдээ ямар ч байсан, бид ингээд шийдэж байгаа биш Их Хурлын тогтоол л доо.

Их Хурал саналаа хураалгаад, Их Хурлын гишүүд дээр бол ярина л даа. Наанатай, цаанатай. Түрүүний хэлдэг Ганболд гишүүний болгоомжлол бол байгаа. Гэхдээ би Түр хороон дарга ч гэсэн энэ юмнуудаа гаргаад, миний хувьд бол тэр Үндсэн хуулийн одоогийн үзэл санааг дэмжж бичиж байгаа ч гэсэн ер нь бол хуульч хүнийхээ хувьд, төрийн захиргаа удирдлагын чиглэлээр бас олон жил хичээл ном заасан хүний хувьд цаашид бүсчилсэн хөгжлийг дэмжиж байгаа нөхцөлд орон нутаг дориухан өмчтэй болох ёстой. Орон нутгийн өмчийн хуультай байх ёстой. Бараг тусад нь салгаж бичмээр байгаа юм. Тэгж яривал.

Б.Энхбаяр: Доржханд гишүүн үгээ хэлье.

Т.Доржханд: Баярлалаа. Тогтоолын төсөлтэй холбоотойгоор 2 зүйл байна.

Нэгдүгээрт, энэ сонсголын үеэр тэр оптек гэрээтэй холбоотой асуудал бол гарч ирсэн байдаг. Тэгээд яг энэ асуудлыг нь анх нээсэн чиглэл өгсөн тухайн үеийн Ерөнхийлөгч байсан Халтмаагийн Баттулга гэдэг хүн сонсголд ирээгүй байдаг. Гэтэл яг өнөөдөр энэ хүн маань ингээд газар яриад гараад ирлээ л дээ. Гадаадын хөрөнгө оруулалт бол болохгүй. Хятад иргэдэд газар эзэмшүүлэх гэж байна гээд. Үгүй ээ тэгээд яагаад энэ сонсголоос зугтааж явсан мөртөө, яагаад одоо энэ Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улсын одоо эв нэгдлийг илэрхийлэгч хүн өнөөдөр ингээд гараад ирэв ээ гэдэг. Энэ бол өөрөө асуудал юм аа. Өөрөөр хэлбэл, хариуцлага хүлээх юман дээрээ зугтаачихдаг. Нэг жилийн өмнө зугтаасан, сая бас зугтаачихсан, тэгсэн шал өөр дүрээр ингээд гараад ирдэг.

Гэтэл хамгийн сүүлд сонсголын яг сүүлийн өдөр бол баримт нь гарч ирсэн шүү дээ. Тэр нь юу вэ гэхлээр 2021 оны 2 сарын 4-ний өдөр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн

даргын ийм албан бичиг санал авъя сайд нар аа, өөрөөр хэлбэл, та нар энэ оптек гэрээтэй холбоотой, үүний санхүүжилттэй холбоотой, тэр төмөр замын асуудлаар та нар саналаа өгөөч ээ гэдэг юм.

Ингээд санал авсан баримтаар гарч ирсэн. Үүний дагуу дараа нь нэг байшин гарч ирсэн. Паркийн хажуу талын байшин. Тэр байшинг хэн эзэмшдэг юм бэ гэхээр тэр бол Голомт банкны санхүүжүүлсэн байшин. Гэтэл тэр худалдан авагч эзэмшигч нар нь дандаа энэ ЭТТ-н удирдлагууд, түүний эргэн тойрны нөхдүүд байсан шүү дээ тийм биз дээ. Удаанжаргал, Ганхуяг мөн биз дээ. Тэгээд энэ чинь ингээд баримтаар бас гараад ирсэн. Тэгээд сонсгол хийж байх үед Хууль зүйн сайд бол албан ёсоор бас байр сууриа илэрхийлсэн гэж бодож байгаа. Нотлох баримтын хүрээнд. Тэр нь юу байна вэ гэхээр, тэр Удаанжаргал болоод Ганхуяг нар тухайн үеийн Монгол Улсын Ерөнхийлөгчийн өрөөнд газрын зураг тавьж байгаад ярьдаг байсан гэдэг, асуудлаа ярьдаг байсан гэж. Би бол яг тэгж бодож байгаа.

Тэгээд энэ нотлох баримтын хүрээнд ингээд гараад ирлээ. Гэтэл бодит байдлаар юу болсон бэ гэхлээр, тэр ерөнхийлөгч маань ирсэнгүй. Сонсголд оролцсонгүй. Тэгээд баримтууд нь гараад ирлээ, одоо яах юм бэ гэж. Тэгэхлээр тогтоолын төсөлд бол цаашаагаа явахдаа бол энэ чиглэлээр хууль хяналтын байгууллагад үүрэг чиглэлээ тодорхой тусгаад явах нь зүйтэй болов уу гэж бодож байгаа юм. Энэ чиглэлээр илүү шалгалтаа эрчимжүүлээд ажиллаач ээ гэдэг, нэгд.

Хоёрдугаарт, энэ нүүрсний сонсголын дараа бас нэлээн хэсэг хүмүүс бол их баяртай байгаа сурагтай байна. Тухайлбал надад ирж байгаа мэдээллээр Санзай гэдэг хотхонд 2, 3 вертолётоор дүүрэн хүмүүс буугаад баяраа тэмдэглэж байна. Энэ бол бодитой мэдээлэл шүү. Тэгээд эндээс бол ямар

дүгнэлт хийж байна гэхлээр жинхэнэ том хулгайч нар маань баяраа тэмдэглэж байна. Тэгвэл хууль очдог юм гэдгийг бүгдээрээ харуулах хэрэгтэй. Мэдээж Улсын Их Хурлын Түр хороо, Улсын Их Хурлын гишүүд хууль хяналтын байгууллагад нөлөөлөх боломжгүй ч гэлээ гэсэн бид нар сонсгол хийсэн биз дээ. Иргэдийг мэдээллээр хангах ажлаа бол хийсэн. Манай шинжээчид маань нотлох баримтуудыг гаргаж ирсэн. Мэдээж шүүмжлэлтэй зүйл байлгүй л яах вэ. Тэгэхдээ л нотлогдсон.

Одоо тэгвэл хариуцлага хүлээх ёстой биз дээ. Бид нар энд сууж байгаа бас шинжээчдийн тал нь бол харж л байна. Хөгжлийн банкны бас сонсголоор бид нар нэлээд олон ил баримтуудыг гаргаж ирсэн. Үр дүнд нь Монголын түүхэнд 80 яллагдагч бүхий ийм шүүх хурал наадам хүртэл 3 сар нээлттэй явсан. Яг наадмын урд өдөр нь тэгээд шийдвэрээ гарсан. Хөгжлийн банкны нэг цөөхөн хэдэн удирдах албан тушаалтан, дунд шатын албан тушаалтнууд ял аваад явсан. Бусад нь зүгээр л чөлөөтэй явчихсан. Одоо нүүрс ингээж явах уу гэж. Тэгээд ийм болохлоор бид нар өнөөдрийн энэ мэдээллийг иргэдэд өгсөн ч гэлээ гэсэн цаашаага бол бид нар энэ хуулийн тогтолцоогоо улс төрөөс хамааралгүй болгох, эрх мэдэлтэй мөнгө төгрөгтэй нөхдүүдээс хамааралгүй болох энэ ажлыг эрчимжүүлэх шаардлагатай юм байна. Тэгээд тийм болохлоор энэ чиглэлийг бас ингээд тогтоолынхоо төсөлд бас тусгаад явах нь зүйтэй болов уу.

Тэгээд цаашид Монгол Улсад ийм том хэмжээний хулгай хийгээд тэгээд асуудал нь ингээд сөхөгдсөн ч гэлээ гэсэн сонсголдоо зугтаагаад явдаг хүмүүст хариуцлага тооцдог, ирж сонсголдоо ордог, орохгүй тохиолдолд орж болдоггүй юм байна гэдэг тэр жишиг тогтоох эрхтэй юм байна гэдэг ийм хувь хүний дүгнэлт бас байна. Цаашид том хэмжээний хулгай хийсэн ч гэсэн 3, 4 жилийн хорих ял аваад сайхан мөнгөтэйгөө үлдэнэ гэж бодож байгаа хүмүүст бол үгүй юм байна гэдгийг бас

бүгдээрээ ойлгуулах ёстой. Тэгээд энэ сонсголын үр дүн, сонсголоос гарсан энэ тогтоолын шийдвэрүүд бас ийшээгээ чиглэсэн байвал зүйтэй байх гэсэн ийм хувь хүний байр суурьтай байна.

Б.Энхбаяр: Гишүүд үг хэлж дууслаа. Ганболд гишүүн тогтоолын төслийн 6 дугаар зүйлтэй холбоотой санал хэлсэн. Тэгэхээр би сая Тамгын газрынхнаас асууж байна. Ингээж санал хураалгая гэж байна.

Ганболд гишүүний микрофоныг өгчихье.

Г.Ганболд: Би бол 6-г хасахгүй, байх ёстой. Тэгэхдээ би ингээд байгаа юм. 29 дүгээр тогтоолын холбогдох заалтыг хүчингүй болгож гэсэн байна шүү дээ. Тэгээд хүчингүй болгож төрийн өмчлөлд эргүүлэн авах тогтоолын төслийг боловсруулан 2024 оны 1 дүгээр улиралд багтаан Их Хуралд өргөн мэдүүлэх гэдэг энэ үгийг хасаад зөвхөн одоо ингээд 29 дүгээр тогтоолын холбогдох заалтыг Үндсэн хууль болоод бусад хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг хянан үзэж шаардлагатай арга хэмжээ авах гэдэг ийм үгээр л оруулчих. Тэгээд эндээ тэр чинь бол орно шүү дээ. Тэгээд шийдвэр гаргах нь бол бид нар ингээж заасан ч, нөгөөдхөөрөө байсан ч засаг шийдвэр гаргаад өргөн барих юм бол боломжтой юм. Тэгэхээр би яг ийм л байдлаар ингээд оруулаад явчихъя гэж бодоод байгаа юм.

Б.Энхбаяр: Тэгвэл Ганболд гишүүний саналаар ингээж байгаа юм байна шүү дээ. Холбогдох заалтыг Үндсэн хууль бусад хууль тогтоомжид нийцүүлэх арга хэмжээ авах, ингэвэл болж байна уу гишүүд.

Тэгвэл 2 санал хураахгүй, шууд тогтоолын төслөө. Тэгээд энэ тогтоолын төслийн 2 дахь заалт нь бол ийм юм байна. Энэ бол зөвхөн орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээд дээр энэ хязгаарлалт нь байхгүй байгаад байгаа

юм байна. Бид нар нөгөө нэг өмнө нь хязгаарласан шүү дээ. Энэ төрийн болон төрийн өмчийн компаниудад улс төрийн хамаарал бүхий хязгаарлалт тэрийг нь хязгаарлалтыг нь хийхдээ зөвхөн төрийн өмчийн компаниуд дээр хийчхээж байгаа юм. Орон нутгийн өмчийн компаниуд дээр хязгаарлалт нь байхгүй байгаа юм байна. Тэгээд харин тэгээд үүнийг нь оруулж ирж байгаа нь энэ 2 гэж.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан.

Одоо Улсын Их Хурлын тогтоолын төслийг сая Ганболд гишүүний хэлсний дагуу би саналын томъёоллыг уншсан. 6 дахь заалтыг. Үүнийг сая уншсанаар дэмжье гэдэг томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт. 85.7 хувийн саналаар тогтоолын төслийг дэмжлээ.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Түр хорооны сүүлийн хуралдаан байгаа.

Түр хорооныхоо гишүүдэд баярлалаа. Мөн хянан шалгах шинжээч нарт, нийт маш богино хугацаанд чанартай ажилласан. Та бүхэнд хэлж байгаа үг бол тогтоолын төсөлд шингэсэн байгаа. Би дахиад уншаад өгчихье. Тогтоолын төслийн үндэслэл хэсэгт Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос зохион байгуулсан Нээлттэй сонголт нь шударга ёсыг тогтоож, иргэдийн мэдэх эрхийг хангах, ард түмэн сонгож байгуулсан төрийн бүх шатны байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, байгалийн баялгийг нийтийн эрх ашигт нийцүүлэн, ард түмний амьдрал ахуйг сайжруулж, улс орны эдийн засгийг хөгжүүлэхэд зориулан зүй зохистой ашиглах, Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал заалтыг хэрэгжүүлэхэд чухал нөлөө үзүүлэх арга хэмжээ болсныг цохон

тэмдэглэж гэж Монгол Улсын Их Хурлаас цохон тэмдэглэсэн байгаа.

Энэ бол Хянан шалгагч, шинжээч та бүхэнд хэлж байгаа талархлын үг байгаа гэдгийг ойлгож хүлээж аваарай. Баярлалаа.

17.02 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ
П.МЯДАГМАА